



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 556

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн АгроЭкологи бизнесийн сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 14,500,000.00 (арван дөрвөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоосугай.

2.Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Ургамал газар тариалангийн хүрээлэн АгроЭкологи бизнесийн сургуулийн захирал Л.Пүрвээд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу байгууллагын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 11 дүгээр...сарын 03..өдрийн
556 дугаар тогтоолын хавсралт

**ХААИС-ИЙН ХАРЬЯА УРГАМАЛ ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ХҮРЭЭЛЭН
АГРОЭКОЛОГИ БИЗНЕСИЙН СУРГУУЛИЙН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН**

№	Тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ			Худалдах доод үнэ
			Нэг бүрний үнэ	НИЙТ Унэ, хурумт лагдсан шалтгаан элэгдэл	/Төгрөг/	
1	Тоёота Xapper 3806 ДАХ, арал MCU100033981	2011	14,500,000.00	14,500,000.00	500,000.00	
				14,500,000.00	500,000.00	
	НИЙТ ДҮН		(арван дөрвөн сая таван зуун мянга)			(таван зуун мянга)